



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/285

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжих Жаргалтхаан сумын 320 хүүхдийн багтаамжтай дунд сургуулийн зураг төсөл, Хэрлэн сумын 1-р сургуулийн 1500 хүүхдийн барилгын зураг төсөв, Хэрлэн сумын 3-р цэцэрлэгийн 200 хүүхдийн барилгын зураг төсөв, Норовлин сумын соёлын төвийн барилгын зураг төсвийн зөвлөх үйлчилгээний ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үүнд:		
Дарга:	Д.Баттулга	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Ц.Бат-Эрдэнэ	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Гишүүн:	Г.Төртогтох	-Боловсрол, соёл, урлагийн газрын төсвийн мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга /Д.Баттулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА